



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 18 өдөр

Дугаар А/390

Мандалговь

Газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай

Монгол улсын Газрын тухай хуулийн 38 дугаар зүйл 38.1,2,4 дэх заалт, газар эзэмших эрхийг шилжүүлэн авах иргэний хүсэлтийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

Нэг. Сайнцагаан сумын төвийн 7 дугаар багийн нутаг дэвсгэр (Худалдааны гудамж-1-124 тоот)-т байршилтай ТОМС ХХК- (РД:2013185)-ны үйлчилгээний зориулалттай 217 м.кв (0,0217га) газрыг Сайнхүү овогтой Батсүх (ЗИ92063014):-д зориулалтаар нь шилжүүлж 23 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

Хоёр. Дээрх иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), мөн гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт, Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч (Р.Мөнхтогтох), аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Төрбат) нарт үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2018 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн А/109 дугаар захирамжийн ТОМС ХХК-д холбогдох хэсэг мөн газар эзэмших 000308254 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.



ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ